



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот

Үндсэн мэргэшлийн сургалтад нэмэлтээр суралцах их эмчийн нэр, мэргэшлийн чиглэл, сургалтын төлбөрийн хэлбэр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс", "Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 15.17.8, 15.17.9 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын "Журам батлах, зардлын жишиг тогтоох тухай" 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн ажилтны 2019-2020 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, хяналтын тоо, сургалтын хөтөлбөрийн жагсаалт, эмнэл зүйн сургагч багшийн төлөвлөгөө, сургалтын зардал батлах тухай" 2019 оны А/121 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Орхон аймаг дах Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүсэлтийг харгалзан "Зоонозын өвчин судлал", "Ерөнхий мэргэшил судлал" төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад 2019 онд нэмэлтээр элсэн суралцах 4 их эмчийн нэр, мэргэшлийн чиглэл, сургалтын төлбөрийн хэлбэрийг хавсралтаар баталсугай.

2. Үндсэн мэргэшлийн сургалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал /Н.Цогбадрах/, Орхон аймаг дах Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал /Б.Батсүх/, нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга /Ц.Лхагва/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081879

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТАД 2019 ОНД НЭМЭЛТЭЭР
СУРАЛЦАХ ИХ ЭМЧИЙН НЭР, МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХЭЛБЭР

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
...¹⁸ сарын ...⁰¹ өдрийн
А/..... дугаар тушаалын хавсралт
1452

№	Овог	Нэр	Регистрийн дугаар, Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Диплом	Төгссөн сургууль	Захиалагч Эрүүл мэндийн байгууллага /хувийн зардлаар суралцагчдын харьяалал/	Суралцах мэргэшлийн чиглэл	Төлбөрийн хэлбэр	Сургалт эрхлэх байгууллага
1. Ерөнхий мэргэшил судлал S(r) 091206 /1 жил/									
1.	Гэлэгравжаа	Оюумаа	ЦА84021664 ИЭ0012290	D201007435	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Ерөнхий мэргэшил судлал	Төрийн сан	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв
2.	Буянхишиг	Мишээл	УХ96010707 ИЭТ0011370	D201906942	Этүгэн их сургууль	Орхон аймаг, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Ерөнхий мэргэшил судлал	Төрийн сан	Орхон Бүсийн оношилгоо эмчилгээний төв
3.	Алтансүх	Алгирмаа	СЛ94020909 ИЭТ0008985	D201814968	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль-Дорноговь салбар	Хэнтий, Эрүүл мэндийн газар	Ерөнхий мэргэшил судлал	Төрийн сан	Орхон Бүсийн оношилгоо эмчилгээний төв

2. Зоонозын өвчин судлал S(г) 091207 /2 жил/

4.	Ашим	Махбал	БЙ89120305 ИЭ0014103	D201306288	Этүгэн их сургууль	Баян-Өлгий, Эрүүл мэндийн газар	Зоонозын өвчин судлал	Төрийн сан	Зоонозын өвчин судлалын үндэсний төв